

МОНГОЛЫН ӨНӨӨГИЙН БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СИСТЕМИЙН ОНОЛЫН ҮҮДНЭЭС СУДЛАХ НЬ

С.Даваадулам

Тэнгэр дээд сургууль

Түлхүүр үгс: систем, системчлэх хандлага, системийн анализ (шинжилгээ), бүтэц, сонгодог структурализм, сонгодог биш структурализм

Боловсролыг танин мэдэхүйн онолын үүднээс судлах нь уг онолын аргуудыг ашиглахаар дамжин хэрэгждэг нь ойлгомжтой. Энэ өгүүлэлд монголын эдүгээгийн боловсролын үйл ажиллагааны зохион байгуулалтыг авч үзэхдээ нийгмийг танин мэдэхүйн янз бүрийн философи арга ба арга зүйн хандлагуудыг хэрэглэсэн бөгөөд гэхдээ голлож системийн тухай онолын хүрээнд боловсруулсан арга зүйн үндэслэлүүдийг ашиглав.

Эхлээд манай судалгаанд арга зүй, эпистемологи утгын хувьд заавал харгалзаж буй гурван ойлголт тус бүрийн агуулгыг товч илэрхийлье. Үүнд, "Системчлэх хандлага", "системийн тухай онол", "системийн анализ (систем шинжлэл)" гэдэг 3 ойлголт хоорондоо холбоотой боловч яг адил биш нь бидний товч судалгааны үр дүнгээр ч гэсэн илэрч байна. Үүнд, системчлэх хандлага бол тухайн объектийг өөрийнх нь дотоод бүрэлдэхүүнүүдэд авч үздэг онол ба арга зүй; системийн тухай онол бол тухайн объектийг бие даасан байдлаар нь биш, харин тэр объектийг орчинтойгоо гарцаагүй харилцан холбоонд байдгийг нь заавал харгалзан үздэг онол, арга зүй; системийн анализ буюу систем шинжлэл нь системийн тухай онолд тулгуурладаг ч гэсэн энэ онолоос бие даан хөгжиж, мэдлэгийн янз бүрийн төрөлд ашиглагдах болж буй арга зүйн хэрэгсэл мөн.

Системийн тухай философи ойлголтын үүсэл. Онолын танин мэдэхүйн янз бүрийн төрөлд системчлэх хандлага ямар нэг хэмжээгээр ашиглагдаж ирсэн түүхтэй ажээ. Энэ нь философид системийн онол үүсэж, хөгжхөд хүргэж, түүний үр шим нь шинжлэх ухаанд төдийгүй техникийн үйл ажиллагаа зэрэг практикт өргөн нэвтэрч байгаа билээ.

Орчин үед систем (тогтолцоо) гэдэг бол философийн нэн чухал нэг категори юм. Философийн үүднээс хамгийн ерөнхийгөөр илэрхийлэхэд систем бол өөр хоорондоо холбоо, харилцаанд оршиж, тодорхой

бүхэллэгийг буюу нэгдлийг бүрдүүлэгч тийм элементүүдийн цогц мөн. Энэ ойлголт ганц философид бус улмаар шинжлэх ухаан, техник, практик үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой. Учир нь, системийн онол нь аливаа объект бүхэллэг байдлаар зохион байгуулагдсан байж, энд тогтолцооны (системийн) элементүүдийн хооронд үүсдэг энерги нь тэдгээр элемент бусад системийн элементүүдтэй холбогдсоноос үүсдэг энергиэс давдаг гэж үзэхийг шаарддаг¹.

Системчлэх хандлагын ийм ач холбогдлыг боловсролын үйл ажиллагаанд буулгаваас уг боловсролын үйл ажиллагааны бүрэлдэхүүнүүдийн өөр хоорондын харилцааны үр дагавар нь тэдгээр бүрэлдэхүүн бусад тогтолцооны бүрэлдэхүүнтэй харьцсанаар бий болдог үр дагавраас илүү их эерэг юм уу сөрөг нөлөөг нийгэмд үзүүлдэг гэсэн үг юм. Жишээ нь, манай боловсролын тогтолцооны аль нэг элементийг, тухайлбал ерөнхий боловсролын дунд сургуулийг онцолбол түүний сургалтын үйл ажиллагааны амжилт нь суралцагчдын амьдралын (гэр бүл, хамт олон, цаг агаар гэх мэт) дотоод, гадаад олон нөхцлээс хамаардаг ч гэсэн хамгийн гол нь тэд (суралцагчид) өмнөх жилүүддээ буюу өмнөх шатны сургуульдаа ба өмнөх ангиуддаа яаж суралцаж ирсэн, багш нартайгаа ямар харилцаа бүхий зэрэг сургуулийнхаа дотоод хүчин зүйлсээс илүү шалтгаалдаг гэж үздэг байхыг системчлэх хандлага шаарддаг.

Ер нь философи мэдлэг анх үүссэн үеэсээ хойш барагцаалбал XIX зууны эхэн хүртэлх хугацаанд системийн тухай танин мэдэхүйн онолын ойлголт философийн түүхэнд ноёрхож ирсэн тухай судлаачид өгүүлдэг юм. Энд жишээ болгож И.Кантын үзлийг онцлох нь илүү тохиромжтой байна. Түүний тайлбараар систем (тогтолцоо) бол нэг үзлээр нэгтгэсэн олон янзын мэдлэгийн нэгдэл мөн. Тийнхүү Кантыхаар онолын систем бол объектив тогтоц биш, харин субъектив байгууламж мөн. Гэхдээ ийм субъектив үзэлтэй зэрэгцээд XIX зууны эхэн үеэс хойш системийн тухай онтологи үзэл, түүний дотор натуралист янз бүрийн тайлбар бий болж иржээ. Өөрөөр хэлбэл дурдан буй үеэс хойш мэдлэгийг системчлэх гэхээсээ илүү мэдлэгийн объектийг нь систем гэж үзэн, түүнийг танин мэдэж болно гэдэг тайлбарууд гарч ирсэн байна. Тухайлбал германы сонгодог идеалист философийн нэг төлөөлөгч Ф.Шеллинг танин мэдэхүйг субъектив чадвар болохыг онцолсон И.Фихте зэрэг философичдын үзэлд шүүмжлэлтэй хандаад угтаа танин мэдэхүй бол ертөнцийн байгууламжаас үндэстэй, өөрөөр хэлбэл объектив

чадвартай хэмээн үзээд натурфилософи бүтээх ажиллагаа явуулсан байна.

Танин мэдэхүйг систем гэж үзэх нь объектив үндэстэй гэдэг үзлийн гол төлөөлөгч бол Г.В.Ф.Гегель билээ. Түүний идеалист систем, диалектик сургаал аль аль нь объектив хандлагад үндэслэжээ.

Марксизм системийг философийн объективизмын нэг хэв маяг болох материализмын үүднээс тайлбарлаж байдаг. Үүнд: энэ сургаал диалектик аргын үүднээс: юмын хөгжилд хэлбэр ба бүтцийг бодвол агуулга нь тодорхойлогч ач холбогдолтой хэмээн үзэж байлаа. Үүний хамт марксизм: тухайн юмын бүтэц бол тэр юмын функцийн үүсэл, өөрчлөлттэй холбоотойгоор уг юмын өөрчлөлт, мөхөл болон шинэ зүйлийн үүсэлд чухал ач холбогдолтой хэмээн ханддаг. Энд бид Марксын "Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь" зохиолын оршил дахь нийгмийн үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцаа, суурь ба давхарга, эдгээр хос үзэгдэл буюу элементийн дотоод диалектик холбоо ба уг холбооны үүсэл, өөрчлөлт нь аль нэг формацийн үүсэл, өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлж байдгийг тайлбарласан арга зүйн хандлагыг иш үндэс болгож байна². Системийг ойлгох объектив, субъектив ийм хоёр өөр хандлага философид үүсэж, өнөөг хүртэл оршиж иржээ.

Харин плюралист арга зүйн үүднээс хандвал аливаа объектийг, түүний дотор боловсролын үйл явц ба түүний зохион байгуулалтыг бүхэлд нь нэг систем гэж үзэх нь тэнд дан ганц объектив юм уу эсвэл зөвхөн субъектив хандлага биш, харин эл хоёр хандлагыг хоёуланг нь шаарддаг байна. Ингэхдээ хүний үйлдлийн, түүний дотор танин мэдэхүйн ба үнэлэмжийн тухайн тодорхой нөхцөлд тийм хоёр хандлагын аль нэг нь нөгөөгөөсөө илүү чухалчлагдаж байдаг. Арга зүйн ийм плюралист зарчмыг америкийн социологич Т.Парсонс бүтэц-үйлийн үүднээс шинжлэх онолдоо боловсруулсан ажээ.

Системийг (тогтолцоог) ойлгох ийм плюралист арга зүйн үүднээс хандвал манай боловсролын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа ба өөр хоорондынх нь харилцаа, холбоог бүхэлд нь нэг тогтолцоо³ мөнийг албан ёсоор хэрхэн ойлгох байдал бол нэг талаар тэдгээрийг байгаагаар нь танин мэдэх зорилт тавьж ирсний, өөрөөр хэлбэл объектив хандлагын үр дүн; нөгөө талаар манай боловсролын үйл асуудлыг онолын боловсруулалт ба удирдах эрх мэдлийн хувьд хариуцдаг хүмүүсийн тодорхой сонирхол, итгэл үнэмшил, ажил-мэргэжлийн чадварын түвшин зэргийн, өөрөөр хэлбэл

субъектив хандлагын үр дүн байх үндэстэй. Үүнд, хэрвээ боловсролын асуудлыг онолын боловсруулалт ба удирдах эрх мэдлийн үүднээс хариуцан шийдвэрлэж буй хүмүүст хувийн сонирхол нь биш, харин мэргэжлийн авьяас чадвар, ажил хэргийн хариуцлага нь тэдний үйл ажиллагааны хэм хэмжээ болж чадаж байгаа бол тэдний гаргасан холбогдох дүгнэлт, зөвлөмж, шийдвэрүүд нэлээд объектив хандлагатай болж чадаж, ажил хэрэгт тусаа өгдөг байх юм. Харин онолын болон улс төрийн шийдвэр гаргах эрх мэдэлтнүүд хувийн ба бүлгийн сонирхолд захируулсан субъектив шийдвэр гаргадаг байвал нийт системийн юм уу түүний тодорхой элементүүдийн хэвийн үйл ажиллагаанд хохирол учруулах эрсдэлтэй байдаг ажээ.

Орчин үед боловсролын үйл ажиллагаа ба зохион байгуулалт бол систем мөний хувьд зөвхөн судлагддаг биш, өөрөөр хэлбэл судалгааны хөдөлгөөнгүй объект болж байдаг биш, бас шинээр эмхлэгдэж, өөрчлөгдөж байдаг. Ийнхүү боловсрол систем болж оршин тогтнох нь түүхэн, одоо, ирээдүйн тогтворт ба өөрчлөлтөт байдлын уялдаа холбооны үр дүн болж байдгийг Монгол улсад боловсролын тогтолцоо анх үүсэн, өөрчлөгдөж ирсэн 80 гаруй жилийн түүх нотолж иржээ.

Аливаа систем тодорхой нэгэн бүхэл мөний хувьд өөрийн гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байдаг болохыг философид заадаг билээ. Гэхдээ тухайн системд зарим элемент нь устаж, зарим нь мөхөх, эсвэл шинэ шинэ элемент бий болох зэрэг үйл явц ямагт хэрэгжиж байдаг гэж болох юм. Энд "устах", "мөхөх" гэдэг хоёр илэрхийллийг дурдсан нь тохиолдлын биш болно. Үүнд, системийн тодорхой элемент дотоод, гадаад шалтгаанаар хөнөөлгөхийг "устах", харин тухайн элемент өөрийн функцийг хэрэгжүүлж дуусаад аяндаа үгүй болохыг "мөхөх" гэж тодорхойлов.

Эдгээр томъёоллыг боловсролын тогтолцоонд холбогдуулан дурдаж байгаа юм. Жишээ нь, Монгол ардын хувьсгалын эхний арван жилд манайд үүссэн бичиг үсгийн бүлгэмүүд нам, төрийн бодлого, арга хэмжээний үр дүнд 1960-аад онуудад янз бүрийн шатны ерөнхий боловсролын болон мэргэжлийн янз бүрийн шатны сургуулиудтай зэрэгцэн улс орон даяар улам өрнөн байгуулагдан ажилласны ачаар манай орон бүх нийтээрээ бичиг үсэгтэн болж үндсэндээ чадсан билээ. Тийнхүү тухайн үедээ манай боловсролын тогтолцоонд хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээтэй боловч чухал шаардлага, ач холбогдол бүхий үүссэн эл элемент (бичиг үсгийн бүлгэмүүд) түүхэн функцээ гүйцэтгээд мөхсөн түүхтэй. Сүүлийн 10 гаруй

жилд Монголын боловсролын тогтолцоонд олон чухал элемент бий болжээ. Тийм элемент бүхэн боловсролын нийт тогтолцооны жич жич шатласан (иерархи) нэг дэд тогтолцоо болж байна. Тэдгээр элементүүдийг буюу дэд тогтолцоонуудыг янз бүрийн логик үндэслэгээний үүднээс илрүүлэн өгүүлэх бололцоотой юм. Тухайлбал:

- Монголын боловсролын өнөөгийн үндсэн зарчмуудыг манай боловсролын тогтолцооны нэг дэд тогтолцоо хэмээн онцолж буй тохиолдолд эдүгээ манай оронд боловсролыг хянах төрийн хяналт дээр олон нийтийн хяналтыг нэмэн оруулсан; боловсрол хүн төрөлхтний соёл иргэншлийн үнэт зүйлсэд (Боловсролын тухай хуулийн 5-1.2 дэх заалтын холбогдох хэсэг) тулгуурладаг болсон; боловсролыг өмчийн зөвхөн нийгмийн хэлбэрт үндэслэн олгодог байсныг өөрчилж, өмчийн төрөл хэлбэр бүр дээр олгох бололцоог зөвшөөрдөг болсон зэрэг чухал чухал элемент энэ дэд тогтолцоонд бий болсныг дурдах шаардлагатай⁴.

- Боловсролын тогтолцоон дахь зохион байгуулалтын дэд тогтолцоо нь боловсролын байгууллагууд юм. Монголд энэ дэд тогтолцоо цааш цаашдаа дэд тогтолцоо болж шатлан хуваагдаж байна. Нэн түрүүнд а) сургалтын; б) эрдэм шинжилгээ, арга зүйн; в) бусад гэдэг дэд системүүдэд хуваагддаг (дурдан буй хуулийн 13.1).

“Сургалтын байгууллага” гэдэг дэд тогтолцоо нь а) сургуулийн өмнөх (цэцэрлэг) ; б) бага боловсролын; в) дунд боловсролын; г) дээд боловсролын хэмээх дэд тогтолцоонууд болон задарч байна. Улмаар “дээд боловсролын сургалтын байгууллага” гэдэг дэд тогтолцоо цааш задрахдаа: а) их сургууль; б) дээд сургууль; в) коллеж хэмээн хуваагдаж байна.

- 1995 онд батласан Боловсролын тухай Монгол улсын хуулийн 23,30 дугаар зүйлүүдэд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагын тухай шинэ заалт анх орсон нь удирдлагын тогтолцооны нэг шинэ элемент болж өгсөн юм. -1995 онд батласан Боловсролын тухай хуулинд болон түүний дараа дараачийн (1998, 2002, 2006 оны) шинэчилсэн хувилбаруудад боловсролын тогтолцооны бас нэг дэд тогтолцоог нэмэн тусгасан нь “боловсролын харилцаанд оролцогчид” гэсэн томъёолол юм. Уг хуулийн зургаа дугаар бүлэгт зааснаар энэхүү дэд тогтолцооны үндсэн элементүүд нь: а) багш; б) суралцагч; в) эцэг эх, асран хамгаалагч; г) аж ахуйн нэгж, байгууллага зэрэг юм⁵.

Энд философи, логикийн харилцан уялдаат нэг санаа хэлэхэд

“тогтолцоо”, “дэд тогтолцоо” гэдэг ойлголтууд харьцангуй байдаг бөгөөд нэг харьцаанд “дэд” буй тогтолцоо өөрөөсөө доод шатлалын харьцааны тогтолцоог өөрийнхөө элемент буюу дэд тогтолцоо болгож, тийм харьцаанд тогтолцооны функц бүхий байдаг. Үүнийг боловсролын тогтолцоонд бүрэн холбогдуулах ёстой.

Боловсролын тогтолцоо, түүний дэд тогтолцоонууд ба тэдгээр тус бүрийн элементүүдийн тухай дээр өгүүлсэн ангилал бол уг ангиллыг зохиогч миний хувийн бодлын үр дүн төдий биш бөгөөд эдгээр ангиллыг хийхдээ дараах хоёр зүйлийг иш үндэс болгов. Үүнд: нэгдүгээрт, 1995 онд анх батлаж, улмаар 1998, 2002, 2006 онд өөрчлөлт, нэмэлт оруулсан Боловсролын тухай Монгол улсын хуулийн агуулга, бүтэц; хоёрдугаарт, ойлголтын багтаамжийн хуваарийн тухай логик онолын дүрмүүд тус тус болно. Монголын өнөөгийн боловсролын тогтолцоог ангилан авч үзэхдээ энд мөрдлөг болгосон логик онолын дүрмүүд нь зөв сэтгэхүйн аливаа холбогдох үйлдэлд ерөнхий арга зүйн ач холбогдолтой, иймд философи ач холбогдолтой байна. Товчлон дурьдахад Монголын боловсролын тогтолцооны дэд тогтолцоонууд ба тэдгээр тус бүрийн элементүүдийг илрүүлэхийн тулд нэг талаар Боловсролын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудыг судлан эзэмших, нөгөө талаар ангиллыг зөв явуулах хуваарийн логик дүрмүүдийг баримтлах хоёр уялддаг байх шаардлагатай.

Монголын боловсролын системт (тогтолцоот) ба бүтэцлэг байдлын харилцан холбоо. Боловсролыг систем (тогтолцоо) гэж үзэх нь түүнийг бас бүтэц (structure) гэж үзэхэд хүргэж байдаг.

Боловсролын бүтцийг философийн үүднээс тайлбарлах нь нилээд төвөгтэй онолын үйл ажиллагаа мөн ба нэн түрүүнд дараахь хоёр үндсэн шалтгааныг дурдъя. Нэгдүгээрт, философийн түвшинд “систем”, “бүтэц” гэдэг хоёр ойлголт аль аль нь тухайн объектийн бүрэлдэхүүн элементүүд ба тэдгээрийн хоорондын холбоо, хамаарлыг авч үздэг бөгөөд мэдлэг, туршлага дутвал тэдгээр ойлголтыг хольж хутгах явдал гардаг тул тус бүрийн агуулгын онцлогийг илрүүлэн ойлгох мэдрэмж ба дидактик ур чадвар өндөр байх шаардлагатай гэж судлаачид үздэг билээ. Хоёрдугаарт, боловсролыг бүтэц хэмээн философийн үүднээс авч үзье гэвэл боловсролын амьдрал, үйл ажиллагааг нарийн судалж эзэмшсэн байх шаардлагатай юм. Хэдийгээр энэ мэт бэрхшээлүүд байдаг ч боловсролыг

философийн үүднээс авч үзэж буй үед, ялангуяа түүнийг систем гэж онцлон шинжилж буй нөхцөлд боловсрол бол бүтэц мөнийг хөндөхгүй байхын аргагүй. Бүтэц бол системийн маш чухал нэг тал, мөн нэг чухал нөхцөл нь болдог. Учир нь гэвэл тэр (бүтэц) нь системт (тогтолцоот) бүхлийн элементүүдийх нь биш, харин тэдгээр элементийн янз бүрийн холбоо, харилцааны нь цогц мөн. Бүтэц нь тодорхой тогтолцоот бүхлийн тухайн тогтворт талыг хангаж өгдөг тул системийн нөхцөл нь болж өгдөг байна. Ингээд бүтцийн тухай сонгодог ба сонгодог биш философи ойлголтуудыг монголын өнөөгийн боловсролын тогтолцоонд буулган тайлбарлая.

Бүтцийн тухай сонгодог философи сургаал монголын боловсролын практик үйл ажиллагаанд холбогдох нь. Бүтцийн тухай сонгодог философи сургаалыг үндэслэгч бөгөөд гол төлөөлөгч нь францын угсаатны зүйч, бүтцийн антропологич Клод Леви-Стросс мөн. Түүний 1958 онд хэвлүүлсэн "Бүтцийн антрапологи" гэдэг номонд нийгмийн бүтцийн тухай дараахь үндэслэлүүд агуулагддаг. Үүнд:

- Нийгмийн бүтэц бол нийгмийн тодорхой үзэгдлүүдийн харилцаа, хамаарал мөн бөгөөд тэнд ямар нэг хүч тэнцвэржүүлэгч зууч болж өгдөг. К.Леви-Стросын судлан тогтоож авсан жишээгээр эртний нийгмүүд дэх бодгаль хүмүүс ба тодорхой бүлэг хүний хоорондох, мөн эмэгтэйчүүд солилцдог тодорхой тооны гэрлэлтийн тогтолцооны хүрээнд, өөрөөр хэлбэл эхийн эрхт ёс бүхий тодорхой овгуудын хооронд үйлчилдэг тэнцвэржүүлэгч хүч нь эмэгтэй хүн байжээ. Энэхүү арга зүйг баримталбаас манай өнөөгийн боловсролын тогтолцооны дотоод бүрдлүүдийн (элементүүдийн) хоорондын болон энэ тогтолцоо олон хэв маяг, түвшинд гадаад орчинтойгоо харилцах харьцааны тэнцвэржүүлэгч хүч нь төр, бүр тодорхой хэлбэл, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал зэргийн холбогдох бүрэн эрх тус тус юм⁶.

- Нийгмийн бүтэц бол хүмүүсийн (овог, аймаг, ард түмэн, улс орны хүн ам гэх мэт) тухайн нийтлэг тус бүрийг өөрийнхөө хүрээнд бүхэлд нь хамарсан байдгийн зэрэгцээ тийм том бүтэц бүрийн доторхи бичил бүтэц байдлаар бас үүсэж, оршиж, өөрчлөгддөг гэж И.Леви-Строс үзсэн юм. Тийм шатлал манай орны боловсролын тогтолцооны (цэцэрлэгийн, бага дунд, дээд сургууль зэрэг) бүх шатанд холбогддог билээ.

- Бүтэц бол тогтолцоог (системийг) тогтворжуулагч хүчин зүйл мөн. Гэхдээ энд нийгмийн тогтолцоог зохиомол байдаг гэж үзэх ёстой. Өөрөөр хэлбэл нийгмийн жич жич бичил бүтэц бол биологи (хүний) тодорхой харилцаа бүхий тус тус бүлэг мөнөөсөө урьд соёлын бэлгэдмэл үзэл (символизм) байдаг. Энэ нь нийгмийн бичил бүтэц бол тодорхой үнэлэмж, хэм хэмжээгээр, бүхэлд нь хэлбэл соёлоор нөхцөлддөг гэсэн үг мөн. Жишээ нь, манай орны ЕБС 10 жилийн сургалттай байсан бол одоо 11 жилд шилжиж улмаар 2008 оноос эхлэн 12 жил болгох тухай холбогдох заалтууд гарчээ.

- Нийгмийн тодорхой үзэгдлийн бүтцийн тухай мэдлэг бол өөр нэг объектоос түүний зарим бүрэлдэхүүн хэсгийг (элементийг) байр шилжүүлэх замаар бий болгосон тийм бүтэц бүхий үзэгдлийн тухай мэдлэг мөн. Яагаад гэвэл, бүтэц бол үзэгдлийн гадна илрэл биш, харин тэр үзэгдлийн дотоод элементүүдийн гүн харилцаа мөн. Жишээ нь өнөөгийн манай боловсролын практикт ардын сурган хүмүүжүүлэх өвийг ашиглах тухай нухацтай ярьдаг болсон нь тэр өвийг зүгээр хуулбарлан дууриах тухай төдий биш, харин түүний түүхэн зориулалт, ач холбогдол, хэрэгждэг байсан нөхцлийг нь судлан тогтоогоод уг өвийг эдүгээгийн нөхцөлд хэрхэн бүтээлчээр ашиглах тухай яриа юм. Ийм замаар 1990-ээд оноос хойш ардын уламжлалт анагаах ухааны мэдлэг манай өнөөгийн анагаах ухааны салбар дахь дээд боловсролын тогтолцоонд материаллаг хэрэгжилттэй, өөрөөр хэлбэл бие даасан дэд элемент нь аль хэдийн болов. Энэ бол уламжлалт анагаах ухааны сургалт манай холбогдох их сургууль, дээд сургууль, коллежид явагдах болсныг хэлж байгаа хэрэг болно. Тийнхүү энэ талаархи бүтээлч шийдвэр, тодорхой ажил хэрэгч зорилт нь манай өнөөгийн боловсролын тогтолцооны зорилтын бүрэлдэхүүн хэсэг болж, тийнхүү монголын боловсролын тогтолцооны нэг элемент болж өгөх үндэстэй.

- Авч үзэж буй бүтцийнхээ гүн дэх гол гол харилцааг илрүүлэн тогтоож, тийм үйл ажиллагааныхаа үнэн эсэхийг практик дээр шалгах хэрэгтэй. Жишээ нь, Боловсролын тухай Монгол улсын багц хууль бол боловсролын байгууллага, төр, багш, суралцагч, эцэг эх, бусад халамжлагч, иргэд зэрэг янз бүрийн байгууллага, хүмүүсийн харилцааг, тэдгээрийн ашиг сонирхлыг зохицуулах зорилт бүхий байж, боловсролын үйл ажиллагааны төдийгүй улс орны нийт амьдралын хүрээнд шалгагдан байнгын засвар, тодорхой шинэчлэлд орж ирсэн билээ.

- Нийгмийн үзэгдэл бүхний бүтэц бол хүний үйлдлийн тухайн тодорхой нөхцөл дэх хэл, тэмдэглэгээ мөн бөгөөд жишээ нь эртний нийгмүүд дэх гэрлэх ёс журам, зан үйл, шидэт домог, баг өмсгөл зэрэг бол тухайн нөхцөл дэх жич жич хэл мөн гэж К.Леви-Строс "Бүтцийн антропологи" зохиолдоо бичсэн байна. Ийм дүгнэлтийг боловсролд бас холбогдуулж болно. Түүхэн тодорхой нөхцөл дэх боловсрол ямар элементүүд, ямар бүтэц, ямар агуулга ба зорилт бүхий байсан, тэр бүгд бол тухайн ард түмний амьдрал, аж төрөх ёс, нийгмийн зохион байгуулалт ямар байсныг илтгэж, тийм утгаар боловсрол бол түүхэн тодорхой хэлний функц бүхий байж, нийгмийн нийт амьдрал ба түүний ямар жич илрэлүүд байсныг илтгэсэн утга бүхий институт болж иржээ.

-Тэмдэглээний буюу аливаа төрлийн хэлний тогтолцоонд (системд) тэмдэглэгдэгч (хэлэгдэгч) нь тэмдэглэгч(хэлэгч)-ээ тодорхойлогч бүтэцтэй байдаг гэж сонгодог структурализм заадаг⁷. Бүтэцлэх аргын энэ дүрмийн үүднээс хандвал Боловсролын тухай Монгол улсын багц хууль (тэмдэглэгч буюу хэлэгч) нь манай орны боловсрол (тэмдэглэгдэгч буюу хэлэгдэгч) ямар байвал зохихыг үнэн, оновчтой илэрхийлэх ёстой аж. Үүнд:

- Монголын боловсролын тогтолцооны бүтцийг тэнцвэржүүлэгч хүч нь боловсролын асуудал эрхэлдэг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд шат шатандаа мөнийг өмнө дурьдсан билээ. Тэдгээрийн тэнцвэржүүлэгч үйл ажиллагааны хэм хэмжээнүүдийг Боловсролын тухай Монгол улсын багц хууль заасан байна. Тэрхүү тэнцвэржүүлэгч функцийг "хуулийн зорилт" хэмээн тэрхүү хуульд томъёолсон байна. Уг хуулийн 1.1-д: "...энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино"⁸ хэмээн томъёолжээ. Гэхдээ энд "тэнцвэржүүлэгч функц" гэдэг ойлголтыг К.Леви-Стросын "тэнцвэржүүлэгч зууч" гэдэг ойлголттой дүйлгэж байгаа болохоос яг адилтгаж буй хэрэг бишээ. К.Леви-Стросын ярьсан тэнцвэржүүлэгч зууч бол эртний нийгэмд ухамсарт бишээр, аяндаа бүрэлдсэн нийгмийн бичил бүтцийн бүрэлдлийг тогтоогч мөн. Харин боловсролын тогтолцоо бол түүхэн уламжлал, улс орны тухайн үеийн амьдралын шаардлаганд үндэслэдэгийн хувьд объектив үндэстэй байдаг боловч тодорхой хүмүүс ба байгууллагуудын итгэл үнэмшил, сонирхол, хүсэл эрмэлзлийг шингээсэн байдгийн хувьд

зохиомол, субъектив шинжтэй байдаг. Тийм учраас ганц боловсролын тухай ч биш, ер нь аливаа хууль, эрх зүйн актууд өөрийн хүрээний харилцааг тэнцвэржүүлэх зорилт тавьдаг боловч яг тэнцвэржүүлэгч хүч байх бололцоо хязгаарлагдмал байдаг.

Бид бүтцийг тогтоон тэнцвэржүүлэгч хүч (зууч)-ийн тухай ийнхүү өгүүллээ. Одоо бүтэц бүхэлдээ тогтолцоог (системийг) тэнцвэржүүлэгч мөн тухай ойлголт руу шилжье. Гэхдээ тухайн бүтэц бол мөнх биш, хөдөлгөөнгүй биш байдаг нь ойлгомжтой. Тухайн бүтэц харьцангуй тогтвортой оршиж байгаа үедээ л тогтолцоог тэнцвэржүүлдэг. Түүнээс гадна тэнцвэржүүлэх үйл бол дандаа эерэг ач холбогдолтой бус, бас цөөнгүй тохиолдол ба нөхцөлд сөрөг ач холбогдолтой байж, үүний улмаас тийм сөрөг ач холбогдол, нөлөө бүхий бүтцийг өөрчлөх, үүний улмаас тогтолцоог бүхэлд нь боловсронгуй болгох шаардлага гарч ирж байдаг. Нийгмийн бичил бүтэц өөрийгөө багтаагч тогтолцоог тийнхүү хөгжил, төгөлдөржилтөнд нь саад учруулан тогтворжуулдаг үйл бүхий буй нөхцөлд уг үйл үндсэндээ албадлага, захиргааны аргад үндэслэж байдаг аж. Ингэхдээ ард түмний уламжлалт соёл, үнэлэмжийн хүчин зүйлд тулгуурлах нь цөөнгүй байдаг ажээ.

Монголд боловсролын тогтолцоо анх үүсэж, улмаар нэг биш удаа өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн түүх нь нийгмийн бүтэц бол тогтолцоог эерэг сөрөг аль нэг үр дагавартайгаар тогтворжуулагч мөн тухай үзлийн нэг баталгаа юм гэж болмоор байна. Жишээ нь, 1963 оны 2 дугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлын 4 дүгээр чуулганаас <<Сургууль амьдралын холбоог бэхжүүлж, ардын боловсролын системийг цаашид хөгжүүлэх тухай>> хуулийг батлан гаргаж, 1956 оноос хойш 7 жилийн боловсролтой сурагчдаар хангах замаар элсэлт нь чанаржин тогтмолжсон тусгай мэргэжлийн техникум буюу хуульд нэрлэдэгчлэн тусгай мэргэжлийн дунд сургууль, 1963 оноос анх эхлэлийг нь тавьж, цаашдаа амжилттай хөгжих болсон техник мэргэжлийн сургууль хоёрыг боловсролын тогтолцооны элементүүд (дэд системүүд) мөнийг нь бататгасан заалт оруулж байв. Энэ нь социализмын нөхцөлд ажиллагчдын цалингийн хэмжээг ажлын чанар, үр дүнгээр биш, харин үндсэндээ ямар шатны сургууль төгссөн дипломын байдалд тохируулан тогтмол тогтоодог байсан харилцаатай уялддаг байлаа. Гэтэл 1990-ээд оноос хойш манай улс зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц эхэлж, энэ нь ялангуяа хувийн хэвшлийнхэн цалинг

дипломоор биш, харин ажлын ур чадвар, чанарт үндэслэн тогтоох тогтолцоонд шилжихэд хүргэж ирсэн; бас аль ч мэргэжил байлаа гэхэд тэр нь боловсролын зохих өндөр түвшинг шаардах болсон зэрэг шалтгааны улмаас цалингийн хэмжээг эзэмшсэн дипломын ялгаагаар нь тогтоодог харилцааны цогцыг 1995 онд баталсан боловсролын тухай Монгол улсын хуулиар халжээ. Тодруулан дурьдахад бүрэн дунд боловсролтой янз бүрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын байгууллага (техникум), бүрэн биш дунд боловсролтой ажилчин бэлтгэх сургууль (ТМС) хоёрын ерөнхий боловсролын түвшний ялгааг арилгаж мэргэжилтэй ажилчдыг бүгдийг бүрэн дунд боловсролтой болгох хууль-эрх зүйн үндэс энэ хуулиар манай оронд бүрэлдсэн билээ. Бичил бүтцийн ийм дэвшил нь боловсролын тогтолцооны элементүүдэд шинэчлэл оруулж, мэргэжил шинээр эзэмшиж буй хүмүүсийн боловсролын түвшинг дээшлүүлэх чухал түлхэц өгч ирсэн байна.

К.Леви-Стросын үзлээр шинжлэх ухаанд өртөж объект нь болдог бүхэн бол нэгэн төрөл хэл, тэмдэглэгээ буюу бүтэц мөн. Жишээ нь эртний овгуудын шүтлэг, миф, баг өмсгөл нь тус бүртээ өвөрмөц хэл мөн⁹. Эндээс арга зүйн ерөнхий дүгнэлт хийхэд хүн төрөлхтний танин мэдэхүйд өртөж, объект нь болдог бүхэн бол бүрэн үнэн мэдлэг өгч чаддаггүй байлаа ч гэсэн ямар нэг утга бүхий мэдлэг илэрхийлдэгийн хувьд тодорхой төрлийн хэл буюу тэмдгийн тогтолцоо болж байдаг. Жишээ нь, Боловсролын тухай Монгол улсын багц хууль бол манай оронд боловсрол ямар үндсэн зарчим, зорилго, тогтолцоо, агуулга, удирдлага бүхий байхыг баталгаажуулсан онцгой нэгэн хэл буюу тэмдэглэгээ мөн. Чухам тиймээс хуулийг ойлгох, хэрэглэх байдал боловсролын харилцаанд оролцогч тал тус бүрт ялгаатай байх тохиолдол бүрдэж, үүний улмаас заримдаа уг хуулийн тодорхой заалтын утга ба практик хэрэгжилтийн үр дүнд хамаарах шүүмжлэл, маргаан гарч байдаг. Энэ нь тэмдгийн (үгний) утга бол тэр тэмдгийг (үгийг) хэрэглэх арга мөн гэдэг семиотик зарчимд нийцдэг билээ.

Бүтцийн тухай сонгодог философи баримтлалуудын дотроос манай боловсролын тогтолцоог шинжлэхэд арга зүйн шууд ач холбоотой үндэслэлүүдийг нь түүвэрлэн товч авч үзэхэд ийм байна.

Бүтцийн тухай сонгодог биш философи үзэл боловсролын онолд холбогдох нь. Нийгмийг танин мэдэхүйд, түүний дотор боловсрол судлалд бүтэцлэх (структуралист) үзэл нь арга зүйн чухал ач холбогдолтой байдгийг дээр авч үзсэн зүйлс ямар нэг хэмжээгээр гэрчилж байна. Гэхдээ

энэ аргын ач холбогдлыг дөвийлгөж болдоггүй. Учир нь, энэ арга объектийн (судалж буй зүйлийн) зөвхөн бүтцийн талыг онцолдог. Иймд бүтэцлэх арга гагцхүү бусад аргатай уялдан хэрэглэгдсэн үедээ танин мэдэхүйн ба үнэлэмжийн, түүгээр зогсохгүй зарим тохиолдолд эвристик (шинийг илрүүлэх) ач холбогдолтой байдаг гэж зарим судлаачид үздэг байна.

Гэвч сонгодог бүтэцлэх арга бусад философи аргатай харилцан холбогдож ашиглагдаж байгаа үедээ хүртэл танин мэдэхүйн хангалттай үр дүн гаргаж чаддагүй тохиолдол цөөнгүй байдаг. Ийм учир дутагдал философийн бусад аргад бас учирдгийг судлаачид тэмдэглэж иржээ. Чухам энэ нь эрдэмтэн хүн өөртөө тохиромжтой ямар ч онол, логик үйлдэл, аргыг ашиглах эрхтэй гэж сурталчилдаг "анархист арга зүй" буюу "арга зүйн анархизм" гэгчийг боловсруулахад хүргэсэн гэж болмоор байдаг. Танин мэдэхүйд ба үнэлэмжийн үйлдэлд сонгодог бүтэцлэх аргын учир дутагдлыг гэтлэн давах янз бүрийн бололцоо бий гэж дээр өгүүлснүүдээс дүгнэн үзэж болмоор юм. Тухайлбал энэ аргыг дээр дурьдсанчлан өөр арга юмуу өөр онол, өөр логик үйлдэлтэй холбон хэрэглэх юм уу эсвэл тэдгээрийн заримаар орлуулах, эсвэл энэ бүтэцлэх аргаа засан сайжруулах гэх мэт бололцоог ашиглах шаардлагатай байдаг.

Эдгээр маягийн бололцоонуудын сүүлчийнхийг нь ашиглах чиглэлд К.Леви-Стросоос хойшхи үеийн зарим структуралист философичид чухал үр дүнд хүрсэн байна. Тэд бол К.Леви-Стросын бий болгосон философийн структурализмын баримтлалуудыг зөвхөн эртний овгийн бүтцийг илрүүлэн судлахад төдийгүй хүмүүнлэгийн ухааны бусад салбарт ашиглах бололцоотой хэмээн үзсэн судлаачид юм. Ийм дүгнэлт хийхдээ сонгодог структурализмд чухал чухал засвар оруулжээ. Тэдгээрээс боловсролын онол, практикт харгалзахад чухал заримыг нь дурдъя.

Нэг. Сонгодог структурализм нь сэтгэхүй бол хүнийг, Би-г тодорхойлдог хэмээн үзсэн Р.Декартын философи баримтлалд үндэслэдэг хэмээн сонгодог биш структурализмыг үндэслэгчдийн нэг, францын философич, сэтгэл судлаач Жак Лакан шүүмжлэлтэй үзжээ. Энэ нь хүн, түүний үйлдэлд ухамсар, сэтгэхүй биш, харин ухамсаргүй сэтгэл, бүр тодорхой хэлбэл хүсэл (либидо) шийдвэрлэх ач холбогдолтой, хүн тийнхүү ухамсаргүй сэтгэлээрээ тодорхойлогддог хэмээгч фрейдизмийн үзэл Ж.Лаканд хүчтэй нөлөөлсний үр дагавар юм. Гэхдээ тэрээр фрейдизмийг шууд хуулбарлалгүйгээр харин түүнд тодорхой шүүмжлэлт байрнаас

хандаж, сэтгэлийн буюу сэтгэцийн бүтцийн тухай З.Фрейдийн үзэлд засвар оруулжээ. Үүнд, Ж.Лакан бие хүний сэтгэцийн буюу сэтгэлийн бүтцийг "Тэр (Ид)", Би (Эго), "Би-дээгүүр (Супер-эго)" хэмээн давхраачилсан З.Фрейдийн үзлийн оронд нь психик (сэтгэцлэг) бодит байдал бол "символон (бэлгэдлийн)", "имагинатив (дүрслэгдэгч)", "бодитой" гурван давхраатай гэсэн үзлийг Ж.Лакан дэвшүүлсэн байна¹⁰.

Хоёр. Сонгодог структурализмын үүднээс бүтцийн тухай мэдлэгт субъектив тал бий ч үндсэндээ объектив тал давамгайлдгийг өмнө өгүүлсэн билээ. Харин сонгодог биш структурализмд субъектив шинжий нь гол гэж үзсэн байна. Жишээ нь, Ж.Лаканы ярьсан символон зүйл нь бодитой ба имагинатив зүйлсийг ноёрхогч тийм бүтэцлэг хүч мөн. Бодитой зүйл бол нэрлэх боломжгүй тохиолдол зүйл, бололцоогүй ба үзэгддэггүй зүйл мөн. Өөрөөр хэлбэл Ж.Лаканы ярьдаг "бодитой зүйл" бол сонгодог онтологид онцолдог материаллаг юм уу санаалаг объектив юм биш, харин символон (бэлгэдлийн) зүйлээс хамааран байнга солигдогч "бодитой" сэтгэл мөн.

Имагинатив (дүрслэгдэгч) зүйл бол символон дэгийн бодгаль илрэл, үүнд нэгдэл рүү тэмүүлдэг бүтэшгүй эрмэлзлэлээс бий болдог бодгаль илрэл мөн гэж Ж.Лакан үзсэн. Түүний үзлээр символон зүйл бол тэмдэглэгч дотор объектив бөгөөд материалагаар байдаг. Тэмдэглэгч бол тэмдэглэгдэгчийг буюу утга, референт (мэдээлэл) зэргийг гарцаагүй тодорхойлдог хэлний материаллаг хэлбэрүүд мөн. Чухамхүү тэмдэглэгчүүдийн гинжүүд хүний үйлийг өгүүлж байдаг. Ийнхүү түүний бүтэцлэх үзлээр мэдлэгийн агуулга нь объектив биш, субъектээс нь хамаармал байдаг гэсэн үзэл орчин үеийн постсонгодог биш танин мэдэхүйн онолд орж ирсэн тухай философийн зарим номонд бичжээ.

Гурав. Тэмдэглээний тогтолцоонд тэмдэглэгдэгч нь тэмдэглэгчээ тодорхойлдог хэмээгч сонгодог структурализмын үзлийг Ж.Лакан засварласан юм. Ийм засвар хийсний философи үндэс нь дээр дурьдсан түүний хоёр баримтлал мөн.

Ж.Лаканы үзлээр бүтцийн психоанализын зорилт бол тэмдэглэгчийн түвшин дэх ярианы цувааны бүтцийг судлах судалгаа мөн бөгөөд энэ бүтэц бол ухамсаргүй сэтгэлийн бүтэцтэй тохирдог. Учир нь, тэмдэглэгдэгч бол ярианы диахрони (хувьслын мөч) дэх дүрслэгдэгч утгат чанартай холбогддог байхад тэмдэглэгч бол бэлгэдлийн (символон) хэлний синхрони (тогтворт төлвийн) талбарын гадна байдаг. Иймд тэмдэглэгч нь

тэмдэглэгдэгчээ тэргүүлж, хэдийчинээ бага утгат чанартай байвал төдийчинээ бат бөх, өөрөөр хэлбэл тэмдэглэх хувилбар нь олон янз, баян байж чаддаг. Ийнхүү Ж.Лакан тэмдэг (хэл) бол тэмдэглэгч, тэмдэглэгдэгч хоёрын салшгүй нэгдэл мөн гэдэг зарим лингвистик баримтлалд, улмаар сонгодог структурализмын үзэлд засвар оруулж, символон (бэлгэдлийн) зүйл буюу тэмдэглэгчийг тэмдэглэгдэгчээсээ хэрэг дээрээ үл хамаардаг гэж үзжээ.

Сонгодог биш структурализмын бусад төлөөлөгчид, үүнд Ролан Барт, "структурализмын үеийн" Мишель Фуко зэрэг францын философичид бүтэц гэж юу болохыг, тэмдэглээний тогтолцооны элементүүдийн харилцаа ямар байдгийг тайлбарлахдаа арга зүйн хувьд Ж.Лакантай адил: тэмдэглэгч бол тэмдэглэгдэгчтэй харьцуулахад шийдвэрлэгч, зонхилогч, иймд тэмдэглэгдэгчтэй харьцуулахад түүнд төвлөрмөл биш, иймд бодгаль шинжтэй байдаг гэж үзсэн байна¹¹.

Бүтцийн тухай сонгодог биш философи баримтлалын үүднээс хандвал боловсролын тогтолцоонд дараах зарим үнэлгээ өгч болох юм. Үүнд:

-Боловсролын үйл ажиллагаагаар олж авч буй мэдлэг бол оюун ухааны, сэтгэж танин мэдэхүйн үр дүн болсон үнэн мэдлэг тэр бүр байдаг биш, өөрөөр хэлбэл боловсролын үйл явцыг яг байгаагаар нь илэрхийлсэн байдал биш, харин янз бүрийн хэв маягийн субъектийн хувийн чанартай, субъектив дүгнэлт, мэдрэмжийн илэрхийлэл болж байдаг. Учир нь, аливаа субъект нийгэм, соёлын үзэгдлийн талаар мэдлэг бий болгох нь тэр субъектийн хүсэл эрмэлзлэлээс хамаардаг. Ийнхүү хэдийгээр субъектийг үгүйсгэдэггүй боловч объектийг илүү онцолж, мэдлэг бол эцсийн эцэст объектоор тодорхойлогддог гэж үздэг сонгодог структуралист арга зүйгээс ялгаатай байр сууринаас сонгодог биш бүтэцлэх арга зүй нь боловсролын асуудалд ханддаг.

- Сонгодог биш бүтэцлэх үзэл нь боловсролыг объектив тогтолцоо болгон авч үзлээ ч гэсэн түүнийг субъектээс үл хамаармал, харьцангуй тогтвортой тогтолцоо гэсэн утгаар биш, харин тухайн сонирхогч, судлагч субъектийн сэтгэлд өгөгдсөн тодорхой байдал гэсэн утгаар ойлгодог. Тодруулан дурьдвал ганц боловсролын тогтолцоо ч биш, ер нь нийгэм, соёлын үзэгдлийн тодорхой тогтолцоо(систем) бүхэн бол судлаачын судалгааны үр дүн, холбогдох хуулийн заалт зэргийн үүднээс тийм

тогтвортой байдаг боловч практик амьдралд, хүмүүсийн үйлдэлд яг тийм тогтолцоо байдаггүй. Тийм учраас аливаа тогтолцооны, түүний дотор боловсролын тогтолцооны талаарх нэгдмэл, ижил мэдлэг бий болгох зорилт бол зөвхөн хүсэл эрмэлзэл байдаг болохоос яг биелж чаддаг зүйл биш гэдэг үзэлд сонгодог биш бүтэцлэх арга зүй хүргэдэг.

Структурализмын сонгодог ба сонгодог биш үзэл ийнхүү мэдлэгийн агуулгын талаар өөр өөр үнэлгээ бий болгодог тул энэ хоёрын алийг нь үнэн гэж үзэх вэ гэсэн сонголтын асуулт гарч ирж болох юм. Ийм асуултанд дараах хариултыг өгч болно гэж үзэж байна. Үүнд, мэдлэгийн агуулга үнэн байх нь түүний (мэдлэгийн) объектоор тодорхойлогддог бөгөөд түүнийг сонгодог структурализм зүйтэй илэрхийлжээ. Гэвч бодит байдалд нэгдүгээрт субъектийн онцлогоос, түүний хүсэл эрмэлзлэлээс хамаараад; хоёрдугаарт объектийг бүрэн, үнэн танин мэдэх бололцоо байдаггүй юм уу нэн ховор байдгийн улмаас хүн төрөлхтний мэдлэг (жишээ нь боловсролын тухай мэдлэг) бүхэлдээ бол субъектив, олон шийдэл бүхий агуулгатай байхад хүрдгийг сонгодог биш структурализмын төлөөлөгчид зүйтэй олж харсан байна. Тийм учраас структурализмын доторх ийм хоёр хандлагыг аль аль нь бүтцийн судалгаа хийдгийнх нь хувьд төдийгүй хамгийн гол нь бие биеэ нөхөж, дүүргэж байдгийнх нь хувьд хоёуланг нь танин мэдэхүйн тохирсон нөхцөлдөө хүчинтэй, харин бусад нөхцөлд өрөөсгөл функц бүхий байдаг гэж үзэх нь зүйтэй санагдаж байна. Тухайлбал боловсролын тогтолцооны талаархи судалгаа бол нийгмийн амьдралын энэхүү маш чухал салбарын талаар объектив агуулга бүхий чухал үр дүн бий болгож байдгийн зэрэгцээ тухайн судлаачийн мэдлэг, туршлагын учир дутагдал, эсвэл түүний хувийн итгэл үнэмшил, төөрөгдөл, хүсэл эрмэлзэл зэргээс хамаарсан өрөөсгөл, алдаатай дүгнэлт гаргадаг эрсдэлтэй гэж үзэхийг арга зүйн хувьд зүйтэй гэж үзэж байна. Ийм дүгнэлтийг хууль тогтоогчид, улс төрчид, ер нь холбогдох нийт субъектийн танин мэдэх, тайлбар хийх, шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаанд хамааруулж болох юм.

Боловсролын талаар сонгодог биш структуралист тайлбар гарч болох танин мэдэхүйн өөр нэг шалтгаан бол янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүс боловсролыг зөвхөн судалж, танин мэддэг төдий биш, түүний тогтолцоог бас бүтээх, өөрчлөх, сайжруулах, удирдах идэвхтэй үйл ажиллагаа явуулдагтай холбоотой юм.

Резюме

Автор в данной статье ставит целью раскрывать методологическое значение теории системы в исследовании структурно-функциональных сторон образовательной системы нынешней Монголии. Основным объектом данного исследования является "Комплектный кодекс Монголий по образованию"

Ном зүй

1. А.Ю.Бабайцев. Система.-Всемирная энциклопедия. Философия. М.-АСТ
Мн.-Харвест, 2001, с.936
2. К.Маркс. Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь. Оршил.
К.Маркс, Ф.Энгельс.Түүвэр зохиол. I боть, УБ.,1969, 559-561 дэх тал
3. Н.Бэгз ийм тогтолцоог улс орны нийт амьдралд авч үзвэл дэд тогтолцоо болж, харин биеэ даасан байдлаараа нэг тогтолцоо мөн гэж 1996 онд хэвлүүлсэн <<Монгол улсын боловсрол>> номынхоо эхэнд тэмдэглэжээ.
4. Боловсролын тухай Монголын улсын хуулийн 5 дугаар зүйлд үзнэ үү.
5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хэрэглэгдэх эрх зүйн баримт бичгийн гарын авлага. УБ.,2003, 28-31 дэх тал
6. Боловсролын тухай Монголын улсын хуулийн 27-33 дугаар зүйлийн үүднээс энэ дүгнэлтийг хийв.
7. Бүтэц ба бүтэцлэг үзлийн зарчмуудын тухай сонгодог философи үндэслэлүүдийг тоочихдоо ашигласан зарим бүтээл: К.Леви-Строс. Структурная антропология. М., 1983; Н.С.Автономова. Структурализм.-Современная западная философия. Словарь. Составители и ответственные редакторы Малахов В.С., Филатов В.П. 2-е изд., переработанное и дополненное. М., 1998; А.А.Горных. Структурализм.- Всемирная энциклопедия. Философия, М.-АСТ-Мн.-Харвест,2001, с.1027-1028; Г.И.Рузавин. Структура. Структурализм.- Философский словарь.Под редакцией И.Т.Фролова. Издание седьмое, переработанное и дополненное. М., 2001, с.543-544; Ц.Гомбосүрэн. Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт

(постструктурализм, постмодернизм). Нэмэлт оруулж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2006, I бүлэг

8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хэрэглэгдэх эрх зүйн баримт бичгийн гарын авлага.УБ.,2003, 4 дахь тал.

9. К.Леви-Строс. Структурная антропология М., 1983, с.56

10.См. об этом в кн.: Ж.Лакан. Функция и поле речи и языка в психоанализе.

М.,1995.

11. Сонгодог биш структурализмын агуулга, арга зүйн онцлогийг илэрхийлэхдээ миний голлон ашигласан бүтээлүүд: Ж.Лакан. Функция поле речи и языка в психоанализе. М., 1995; Н.С. Автономова. Лакан.- Современная западная философия. Словарь. М., 1998, с. 208-210.